



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/247

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам" –ын 4.3.8, 9.12, 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн Бат-Өлзий сумын төвийн гэрэлтүүлгийн урсгал засварын гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)  
Гишүүд: С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)  
Э.Дашдулам (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)  
Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)  
Г.Санжидсүрэн (Цахилгаан эрчим хүчний техникч)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний шаардлагыг биелүүлсэн нөхцөлд, акт үйлдэн хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Бямбагарав), хөрөнгийг байгууллагын бүртгэлд бүртгэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон Бат-Өлзий сумын төвийн гэрэлтүүлгийн урсгал засварын ажлыг ашиглалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Э.Дашдулам) нарт тус тус үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Н.ОРХОНТУУЛ

